



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МОНГОЛБАНК (УДИРДЛАГЫН БАГ)-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, ҮР ДҮН

2019-2025



АГУУЛГА


1.	Монгол Улс ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарав	1
2.	Ковид-19 цар тахлын үеийг даван туулж, эдийн засаг тогтворжив	3
3.	Инфляц нэг оронтой тоонд хадгалагдав	5
4.	Гадаад Валютын Албан Нөөц түүхэн дээд хэмжээнд хүрч нэмэгдэв	7
5.	Валютын ханш тогтвортой байв.....	9
6.	Монгол Улсын зээлжих зэрэглэл түүхэн дээд түвшинд хүрч сайжрав	11
7.	Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцлийн гэрээний ашиглалтын үлдэгдлийг хоёр дахин буурууллаа	13
8.	Санхүүгийн салбарын эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлээ	14
9.	Активын чанарын үнэлгээг гүйцэтгэв	16
10.	Банкууд нээлттэй хувьцаат компани боллоо	18
11.	Уур амьсгалын бодлого, санхүүгийн тогтвортой байдлыг уялдуулах чиглэлд манлайлж ажиллав.....	20
12.	Уул уурхайн бус экспорт, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг дэмжиж ажиллалаа	23
13.	Ипотек зээлийн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэв	25
14.	Монгол Улсын төлбөрийн систем шинэ шатанд гарав.....	27
15.	Зээлжих чадварыг оноогоор үнэлдэг зээлжих зэрэглэл тогтоох системийг нэвтрүүлээ	29
16.	Банкны салбарт их өгөгдлийн систем нэвтэрч, статистикийн цар хүрээг өргөжүүлэв.....	30
17.	Иргэдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох үйл ажиллагааг өргөжүүлэв 32	
18.	Их хааны хөшөөг үндэсний музейд залав	34
19.	Монголбанкны бодлого, үйл ажиллагааг өндрөөр үнэлэв.	36
20.	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэв	37
21.	Дүгнэлт	39

1. МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН СТРАТЕГИЙН ДУТАГДАЛТАЙ ОРНУУДЫН ЖАГСААЛТААС ГАРАВ

Монгол Улс саарал жагсаалтад оров. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн бүсийн орнуудын Мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ээс 2017 онд анх удаа манай улсад “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо (МУТСТТ)-ны харилцан үнэлгээ”-г хийв. Үнэлгээний үр дүнд ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 20 нь хангалтгүй, хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн хоёроос бусад нь хамгийн бага үнэлгээ авсан тул Монгол Улс 2019 оны 10 сард ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт (Саарал жагсаалт)-д орсон юм.

Богино хугацаанд саарал жагсаалтаас гарав. Монголбанк 2020 онд багтан ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах зорилтыг тавьж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласнаар Монгол Улс 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар “Саарал жагсаалт”-аас албан ёсоор гарав. Уг жагсаалтаас гарахад төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Ийнхүү богино хугацаанд тус жагсаалтаас гарсан нь Монголбанк, түүний дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудын хүчин зүтгэл, хамтын ажиллагааны үр дүн байлаа.

Монгол Улс МУТСТТ-г сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн 2019-2024 он



Эх сурвалж: Монголбанк

Европын Холбооны хар жагсаалтаас гарлаа. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, түүний дэргэдэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд эрчимтэй хамтран ажиллаж, ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавруудыг шуурхай биелүүлснээр Монгол Улс ФАТФ-ын "Саарал жагсаалт"-аас гарч, үүний үр дүнд Европын Комиссоос Монгол Улсыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй улс орнуудын жагсаалтаас гаргахаар шийдвэрлэв. Уг жагсаалтаас гарснаар Европын Холбооны гишүүн орны банк, санхүүгийн байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох,

Европын Холбооны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нэмэгдэх нөхцөл бүрдэв.

ФАТФ-ын 40 зөвлөмжийг бүрэн хангасан орон боллоо. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 26 дахь удаагийн жилийн уулзалтаар Монгол Улсын 6 дахь удаагийн явцын тайланг хэлэлцэж батлав. Монгол Улсын явцын тайланд ФАТФ-ын “Зөвлөмж 8”-д заасны дагуу ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, холбогдох хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийн талаар тайлагнасан. Үүний үр дүнд, Монгол Улс нь ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон (Зөвлөмж 15-ыг шинэчилсэн үнэлгээгээр), дэлхийд 5 дахь орон боллоо. Энэ нь ФАТФ-аас гаргасан 40 зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай эрх зүйн орчныг бий болгож, зохицуулалтыг боловсронгуй болгосныг олон улсын түвшинд баталгаажуулж буй явдал юм.

2. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙГ ДАВАН ТУУЛЖ, ЭДИЙН ЗАСАГ ТОГТВОРЖИВ

Ковид-19 цар тахлын хямрал нүүрлэв. Ковид-19 вирус дэлхий нийтээр хурдацтай тархаж, цар тахлын түвшинд хүрч улс орнуудын эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг авчирч, нийлүүлэлт төдийгүй эрэлтэд нэгэн зэрэг сөргөөр нөлөөлж эхэлсэн. Цар тахлаас үүсэж буй энэхүү өөрчлөлт нь 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас илүү сөрөг хор уршигтайг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байв. Цар тахлын энэхүү хямрал нь өрхийн амьжиргаа, бизнесийн байгууллагын санхүүгийн байдалд шууд сөргөөр нөлөөлж, улмаар санхүүгийн тогтвортой байдалд өндөр эрсдэл учруулж байгаа нь бодлого боловсруулагчдын өмнө шинэ, томоохон сорилтыг бий болгож байв.

Эдийн засгийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Олон улсын туршлагад суурилан Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон Монголбанкнаас эдгээр хүндрэлүүдийг даамжрахаас сэргийлэх зорилгоор сангийн болон мөнгөний бодлогын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэв. Эдгээр бодлого, арга хэмжээний хүрээнд Засгийн газраас 2021 оны 2-р сарын 17-ны өдөр “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г боловсруулж баталсан юм.

Зээл, санхүүжилтийн арга хэмжээг хэрэгжүүлэв. Эдийн засгийг сэргээх цогц төлөвлөгөөний хүрээнд 2021-2022 онд нийт 6.9 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээл олгохоор төлөвлөсөн бөгөөд Засгийн газраас 2021-2024 жилд дунджаар 70-80 тэрбум төгрөгийн хүүний дэмжлэгийг олгохоор тооцсон. Энэ нь хүүтэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэд, малчдад санхүүгийн дэмжлэг болж, бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангана гэж үзсэн юм. Үүний үр дүнд 2021-2022 онд нийт 71,339 зээлдэгчид 5.8 их наяд төгрөгийн санхүүжилт олгож, улсын хэмжээнд 176.9 мянган ажлын байрыг хадгалахад дэмжлэг үзүүлжээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт 2021-2022, тэрбум ₮

Зээл, санхүүжилтийн хөтөлбөр	Зээлийн дүн		Зээлдэгчийн тоо	Хадгалсан ажлын байр
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Ажлын байрыг дэмжих зээл	2,000.0	1,965.6	25,515	109,763
Урт хугацаат репо санхүүжилттэй зээл	2,000.0	1,311.4	3,659	67,128
Орон сууцны ипотекийн зээл	2,000.0	1,688.1	20,070	
Хөдөө аж ахуйн зээл	880.0	789.3	22,096	
Нийт	6,880.0	5,754.3	71,339	176,891


Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас Ковид-19-ын цар тахлын үед хэрэгжүүлж буй төв банкуудын сайн туршлагыг судалж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. (i) ЖДҮ, уул уурхайн бус экспортын салбараас эхлэн боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдааны салбар, нөөцийн мах бэлтгэл, эм эмнэлгийн хэрэгслийн салбар, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлийн эх үүсвэрийг 3 хүртэл жилийн хугацаатай репо арилжаагаар олгосон. Энэ үйл ажиллагаа нь цар тахлын үед зээл

олголт зогсож, банк санхүүгийн систем дэх мөнгөний урсгал удаашраад байсан сөрөг нөлөөг бууруулах ач холбогдолтой байв. (ii) Өрхийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор ипотекийн хөтөлбөрийн зээлтэй иргэдийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах арга хэмжээг нийт 5 удаа авч хэрэгжүүлсэн юм. Үр дүнд нь 63.2 мянган өрхийн 3.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй зээлийн төлбөрийг 2022 оныг дуустал хугацаанд хойшлуулав. (iii) Цар тахлын үед эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид зориулсан урьдчилгаа төлбөр төлөлгүйгээр түрээслээд өмчлөлд шилжих нөхцөлтэй орон сууцжуулах тусгай хөтөлбөрийн хүрээнд НОСК ХК-аас гаргасан үнэт цаасыг худалдан авснаар нийт 1,594 төрийн албан хаагчдыг урьдчилгаа төлбөр шаардахгүйгээр орон сууцжуулав. (iv) Шатахууны нийлүүлэлтийн тасалдлаас үүсэж болох инфляцын эрсдэлийг бууруулж, төгрөгийн тогтвортой байдлыг хангах, газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх зорилгоор шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилт олгов.

Цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээний улмаас эдийн засгийн идэвхжил сулраад байв. Монгол Улсын эдийн засаг 2020 онд сүүлийн 30 жилийн хамгийн огцом уналттай буюу 4.6 хувиар агшив. Цар тахлын тархалтаас сэргийлэх бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы нөлөөгөөр бизнесийн орчинд тодорхой бус байдал нэмэгдэж, бизнесийн идэвхжил огцом сулран, хөдөлмөр эрхлэлт буурч, зарим үйлдвэрлэл, үйлчилгээ тодорхой хугацаанд тэг зогсолт хийхэд хүрсэн. Улмаар уул уурхай болон үйлчилгээний дийлэнх салбарууд огцом агшсан, аж үйлдвэрийн салбарын өсөлт саарсан нь ийнхүү эдийн засгийн идэвхжил сулрахад нөлөөлж байв.

Монгол Улсын ДНБ-ий өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засаг тогтворжив. Засгийн газар, Монголбанкнаас цар тахлын сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын багц арга хэмжээний нөлөө болон хүн амыг Ковид-19-ын вакцинжуулалтад шуурхай хамруулсны нөлөөгөөр иргэдийн хөдөлгөөнт байдал, хэрэглэх хандлага нэмэгдсэний зэрэгцээ хөдөлмөрийн захад эерэг өөрчлөлтүүд давамгайлж, хэрэглээ, үйлдвэрлэл сэргэж эхлэв. Улмаар 2022 оноос эхлэн эдийн засгийн идэвхжил хүлээлтээс давж, цар тахлын өмнөх үеийн түвшинд очин тогтворжлоо.

3. ИНФЛЯЦ НЭГ ОРОНТОЙ ТООНД ХАДГАЛАГДАВ

Ковид-19 цар тахлын үед инфляц хоёр оронтой тоон хүрэв. 2020 оноос Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хөл хорио, ОХУ-Украин дайн, олон улсын худалдааны хурцадмал байдал, тээврийн саатал болон зуд, малын халдварт өвчний дэгдэлт зэргээс шалтгаалан гадаад, дотоод эдийн засгийн эрсдэл, тодорхой бус байдал нэмэгдсэн юм. Үүнтэй холбоотой тээврийн зардал, шатахууны үнэ болон худалдааны түнш орнуудад инфляц нэмэгдсэнээр импортын барааны үнэ эрчтэй өсөж, дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж, улмаар 2022 оны 6 сард улсын инфляц оргил үедээ 16.1 хувьд хүрч байв.

Монгол Улсын инфляц, 2019-2025 он



Эх сурвалж: Монголбанк

Бодлогын хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Монголбанк гадаад, дотоод эдийн засагт үүссэн хүндрэлийг үнэлэн, хариу арга хэмжээний хувилбаруудыг тооцож, бодлогын шийдвэрүүдийг авч хэрэгжүүлэв. Ингэхдээ үнийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлахыг зорин ажиллав. Тодруулбал, гадаад өрийн эргэн төлөлтийг хойшлуулж, доноруудын том дүнтэй санхүүжилтийг татан төвлөрүүлж, алт худалдан авалтыг нэмэгдүүлсэн. Банкны системд зээлийн тасалдал үүсэх, жижиг, дунд үйлдвэрлэл болон уул уурхайн бус экспортын салбарыг дэмжихээр урт хугацаат репо санхүүжилтийг нэвтрүүллээ. Түүнчлэн, малчдын зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлийн хугацааг сунгаснаар өрхийн санхүүгийн дарамтыг багасгаж, хэрэглээг дэмжихэд чиглэлээ. Мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах, үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанканд байршуулсан төгрөгийн харилцах, заавал байлгах нөөцийн урамшуулал, заавал


байлгах нөөцөөс хасагдах эх үүсвэр зэрэг хэрэгслийн нөхцөлийг бодлогын зорилттой уялдуулан шинэчлэн тогтоов. Ийнхүү Монголбанк мөнгөний уламжлалт болон уламжлалт бус хэрэгслийг ашиглан цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогын хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Инфляц нэг оронтой тоонд хадгалагдав. Монголбанкны зүгээс авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ үр дүнгээ өгч улсын инфляц 2023 оны 10 дугаар сард 9 хувь болж нэг оронтой тоонд, цаашлаад 2024 онд 4.6 хувь болж бууран, инфляцын зорилтот интервалд орж, тогтворжив. Улмаар инфляцын түвшин 2025 оны 11 дүгээр сард 8.2 хувьтай гарснаар нэг оронтой тоонд 26 дахь сардаа хадгалагдаж байна. Инфляц ийнхүү нэг оронтой тоонд хадгалагдаж байгаа нь иргэдийн бодит орлогыг хамгаалах, бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

4. ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЧ НЭМЭГДЭВ

Гадаад валютын албан нөөц (ГВАН) түүхэн дээд түвшинд хүрэв. Монгол Улсын ГВАН 2025 онд түүхэн дээд түвшин буюу 6.0 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.0 тэрбум ам.доллар буюу 21 хувиар өссөн байна. Ийнхүү манай улсын валютын төлбөртэй импортын хэрэгцээний 5.6 сарын хэрэгцээг, богино хугацаатай гадаад өр төлбөрийг 285 хувь хангах түвшинд хүрч төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хамгаалсан нь эдийн засгийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой юм. ГВАН-ийг илүү уян хатан бүтэцтэй болгосноор арга хэрэгслүүд нэмэгдэж, санхүүжилт татах боломжийг өргөжүүлээд байна.

Гадаад валютын албан нөөц, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад валютын нөөцийг удирдав. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын экспорт хурдацтай буурч, Засгийн газрын баталгаатай аж ахуйн нэгжийн гадаад бондын төлбөр гадагшаа хийгдэж, төлбөрийн тэнцлийн алдагдал гүнзгийрч, 2022 оны 8 дугаар сард ГВАН 2.7 тэрбум ам.долларт хүрч буураад байв. Харин Монголбанкны зүгээс экспортлогч ААН-үүдтэй хамтран ажиллах, үнэт металл тушаалтыг нэмэгдүүлэх, алт олборлогч аж ахуйн нэгжид урьдчилгаа санхүүжилт олгох, банкуудыг олон улсын зах зээлээс гадаад валютын эх үүсвэр татах илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх, гадаад валютын зах зээлд огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр ам.доллар худалдан авах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Ингэснээр ГВАН 2023 оны эцэст 4.9 тэрбум ам.доллар, 2024 онд 5.5 тэрбум ам.доллар, 2025 оны 12 сард 6.0 тэрбум ам.долларт хүрч сүүлийн гурван жил дараалан түүхэн дээд түвшнийг шинэчлэн тогтоолоо.

Гадаад өр төлбөрийг амжилттай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэв. Гадаад өрийн удирдлагын хүрээнд олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын болон хувийн

хэвшлийн бондуудын эргэн төлөлтөд зориулан шаардлагатай гадаад валютыг тухай бүр нийлүүлж ажиллаа. Тухайлбал, 2022 онд МИК ОССК ХХК-ийн бондын төлбөрт 103 сая ам.доллар, Чингис бондын 1 тэрбум ам.долларын төлбөрт 136 сая ам.доллар, 2023 онд Засгийн газрын гадаад зээл, бондын эргэн төлөлтөд цэвэр дүнгээр 300 орчим сая ам.доллар, Монгол Улсын Хөгжлийн банкны евро бондын эргэн төлөлтөд 500 сая ам.доллар, Самурай бондын эргэн төлөлтөд 30 тэрбум иен, Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн ашиглалтаас 1.5 тэрбум юань, 2024 онд Засгийн газрын гадаад зээл, бондын эргэн төлөлтөд цэвэр дүнгээр 450 сая ам.доллар, Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн үлдэгдлээс 4.5 тэрбум юанийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн. ГВАН-ийн тогтвортой өсөлт болон эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд гарч буй эерэг өөрчлөлтийн үр дүнд Монгол улсын зээлжих зэрэглэл сайжирч, төгрөгийн ханшийн хэлбэлзэл тогтворжиж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэснээр олон улсын зах зээлээс татах санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, өртөг буурахад эерэг нөлөө үзүүлээ.


Үнэт металлын худалдан авалт түүхэн дээд хэмжээнд хүрэв. Монголбанкнаас гадаад валютын нөөцийн тогтвортой, хүрэлцээтэй байдлыг хангах хүрээнд сүүлийн 6 жилд нийт 130 тонн үнэт металл худалдан авч, мөнгөжүүлсэн бөгөөд энэ хүрээнд гадаад валютын нөөцийг 5.8 тэрбум ам.доллараар нэмэгдүүллээ. Тухайлбал, Монголбанк нь “Алт 2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолд үндэслэн гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. Үүний хүрээнд 2020 оны 6 дугаар сараас 2022 оны 12 дугаар сарын хугацаанд алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд нийт 505.5 тэрбум төгрөгийн урт болон богино хугацаатай, хөнгөлөлттэй санхүүжилтийг арилжааны банкуудаар дамжуулан олгож ажиллав. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлсний үр дүнд, 2020 онд 23.6 тонн, 2021 онд 20.8 тонн, 2022 онд 22.9 тонн, 2023 онд 17.9 тонн, 2024 онд 16.5 тонн, 2025 онд эхний 11 сарын байдлаар 13.6 тонн үнэт металлыг тус тус худалдан аваад байна.

5. ВАЛЮТЫН ХАНШ ТОГТВОРТОЙ БАЙВ

Ковид-19 цар тахлын үед валютын ханшийг бага түвшинд хадгалав. Цар тахлаас шалтгаалан улс хоорондын гадаад худалдаа саатаж, дэлхий даяар урсгал тэнцлийн алдагдал өсөх, хөгжиж буй орнуудад үндэсний валютын ханш сулрах үзэгдэл ажиглагдсан ч Монголбанкнаас санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалах тодорхой бус байдлыг бууруулах бодлогын чиглэлийг баримтлан ажиллав. Улмаар цар тахлын үед төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн хэлбэлзэл харьцангуй тогтвортой хадгалагдав. Энэ нь санхүүгийн зах зээлийн орчинд тодорхой бус байдлыг бууруулах замаар бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг болохын зэрэгцээ импортын бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэлтэй инфляцын дарамтыг бууруулах, гадаад валютаар төлөгдөх өрийн үйлчилгээний зардлыг өсгөхгүй байх чухал ач холбогдолтой байв.

Валютын ханшийн хэлбэлзлийг бууруулах бодлогын арга хэмжээг идэвхтэй авч хэрэгжүүлэв. Цар тахал, олон улсад өрнөж буй геополитикийн маргаанаас үүдэлтэй нийлүүлэлтийн сүлжээний саатлаас бий болсон эдийн засгийн хүндрэлүүдийг амжилттай даван туулах зорилгоор Монголбанк гадаад валютын зах зээлд хямралаас урьдчилан сэргийлж, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг идэвхтэй авч хэрэгжүүлэв. Тухайлбал, стратегийн бараа бүтээгдэхүүний импортыг тасалдуулахгүй байх зорилгоор гадаад төлбөр тооцоонд нэн шаардлагатай гадаад валютын нийлүүлэлтийг хэвийн түвшинд хадгаллаа. Ингэснээр нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын эрсдэлийг бууруулж, иргэдийн орлогын худалдан авах чадвар буурахаас сэргийлэв.

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Валютын ханшийн хэлбэлзэл буурч байна. Эдийн засаг, улс төрийн тодорхой бус байдал өндөртэй байсан сүүлийн жилүүдэд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарахын зэрэгцээ гадаад валютын зах зээлд гажуудал үүсэхээс сэргийлж, эрэлт,


нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож байна. Тухайлбал, 2025 оны эхний 11 сарын байдлаар 91 удаагийн гадаад валютын дуудлага худалдааг зохион байгууллаа. Үүний үр дүнд 2010 оноос хойш 10 жилийн хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш жилд дунджаар 7.1 хувиар суларч байсан бол сүүлийн 6 жилд ханшийн сулрал 4.7 хувь, сүүлийн 3 жилд 1.0 хувь болж буурснаар хэлбэлзэл нь 2010-2019 онтой харьцуулахад харгалзан 1.5, 7 дахин багасав. Мөн 2025 оны 12 дугаар сарын байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,549 төгрөгт хүрч оны эхнээс 3.4 хувиар сулраад байна.

6. МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЧ САЙЖРАВ

Ковид-19 цар тахлын үед Монголбанк Засгийн газартай хамтран ажиллаж, зээлжих зэрэглэлийг тогтвортой хадгалав. Монголбанк 2020 онд Монгол Улсын Засгийн газартай хамтран олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч, Мүүдиз, Эс энд Пи агентлагуудтай цахим уулзалтуудыг зохион байгуулав. Улмаар Фитч агентлагаас 2020 оны 5 дугаар сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В”, ирээдүйн төлөвийг “Тогтвортой” хэвээр үнэлсэн бөгөөд зээлжих зэрэглэл харьцангуй тогтвортой байсан нь Монгол Улс гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалж, Ковид-19 цар тахлын үед гадаад өрийн үйлчилгээг дахин санхүүжүүлэхэд дэмжлэг болов. Цар тахал, геополитикийн шокууд нь дэлхийн эдийн засагт эрсдэл учруулж, хөгжиж буй орнуудын зээлжих зэрэглэл унасан боловч Монгол Улсын зээлжих зэрэглэл 2021, 2022 онуудад хэвээр хадгалагдав.

Монгол Улсын зээлжих зэрэглэл түүхэн түвшинд хүрч сайжрав. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч гол гурван агентлаг 2024 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В+”, “В+”, “В2” болгон ахиулсан. Зээлжих зэрэглэл өсөхөд эдийн засгийн сэргэлт, гадаад төлбөрийн чадвар сайжирсан байдал, инфляцын бууралт, мөн гадаад өрийн оновчтой удирдлага зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байв. Зээлжих зэрэглэл сайжирснаар Засгийн газар болон аж ахуйн нэгжүүд олон улсын санхүүгийн зах зээлээс илүү таатай нөхцөлөөр санхүүжилт татах боломж нэмэгдэнэ. Үүний тод илрэл нь Голомт банк болон Худалдаа хөгжлийн банк олон улсын зах зээлд нийт 350 сая ам.долларын бондыг өмнөх хэлцлээс бага хүүтэйгээр амжилттай арилжаалж, санхүүжилтийн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн явдал юм. Мөн Монгол Улсын макро эдийн засаг, гадаад төлбөрийн чадвар сайжирсан, эдийн засгийн өсөлт эрчимжсэн, төсвийн болон гадаад өрийн оновчтой бодлого хэрэгжүүлсэн зэрэг эерэг үр дүн 2025 онд хадгалагдсанаар Эс энд Пи агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “BB-”, Мүүдиз агентлаг манай улсын зээлжих зэрэглэлийг “B1” болгон дахин ахиулав. Ийнхүү Монгол Улсын зээлжих зэрэглэл 2 жил дараалан дээшилснээр түүхэн дээд түвшинд хүрлээ.

Монгол Улсын зээлжих зэрэглэл




Эх сурвалж: Сангийн яам

ОУВС банкны салбарын нөхцөл байдал, хэтийн төлөвийг харьцангуй тогтвортой гэж үнэлэв. ОУВС-гийн дүрмийн 4 дүгээр заалтын хэрэгжилтийн дагуу Монгол Улсыг хариуцсан ажлын хэсэг 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 7 дугаар сарын 04-ний өдрийн хооронд ажиллаж, макро эдийн засгийн төсөөллийг шинэчлэн, холбогдох бодлогын зөвлөмж бүхий тайланг боловсрууллаа. Улс орнууд ОУВС-гийн гишүүн болсноор тус сангийн дүрмийг зөвшөөрч, дүрмийн IV дэх заалтын дагуу тогтсон хугацаанд эдийн засаг, санхүүгийн секторын тогтвортой байдлаа үнэлүүлэх, зөвлөлдөх хэлэлцээг хийдэг билээ. Улмаар ОУВС-гаас 2023 оны 10 дугаар сарын 04-нд холбогдох тайланг нийтэлсэн бөгөөд Монгол Улсын эдийн засаг болон банкны салбарын нөхцөл байдал, хэтийн төлөвийг харьцангуй тогтвортой гэж үнэллээ.

7. ХЯТАДЫН АРДЫН БАНКТАЙ ХИЙСЭН СВОП ХЭЛЦЛИЙН ГЭРЭЭНИЙ АШИГЛАЛТЫН ҮЛДЭГДЛИЙГ ХОЁР ДАХИН БУУРУУЛЛАА

Монголбанк Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцлийн ерөнхий гэрээг сунгав. Монголбанк нь Хятадын Ардын Банктай (ХАБ)-тай “Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн ерөнхий гэрээ”-г хоёр орны худалдааг дэмжих замаар эдийн засгийг хөгжүүлэх, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах зорилгоор анх 2011 онд 5 тэрбум юанийн дүнтэй байгуулж байсан бөгөөд 2012, 2014 онд тус бүр 5 тэрбум юаниар нэмэгдүүлж 15 тэрбум юаньд хүргэсэн. Гэрээний хугацааг 2014, 2017, 2020 онуудад тухай бүр 3 жилийн хугацаагаар сунгасан бол 2023 онд ХАБ-тай зөвшилцсөний үр дүнд своп хэлцлийн ерөнхий гэрээний зарим нөхцөлүүдийг сайжруулж, хугацааг 2026 он хүртэл сунгаад байна.

Хятадын Ардын банктай хийсэн своп хэлцлийн үлдэгдэл, тэрбум юань



Эх сурвалж: Монголбанк

Своп хэлцлийн ашиглалтаас нийт 6 тэрбум юанийн эргэн төлөлтийг хийж үлдэгдлийг хоёр дахин буурууллаа. 2023-2024 онуудад төлбөрийн тэнцлийн ашиг нэмэгдэж, Засгийн газрын гадаад бондуудын дахин санхүүжилт амжилттай шийдвэрлэгдсэн. Улмаар гадаад валютын улсын нөөцөд үзүүлэх гадаад секторын дарамт харьцангуй тогтворжсон тул Монголбанк нь Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, Төв банкны хүүний зардал, алдагдлыг бууруулах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн үлдэгдлээс 2023 онд 1.5 тэрбум, 2024 онд 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг тус тус гүйцэтгэж, нийт ашиглалтын үлдэгдлийг 6 тэрбум юань болгон 2 дахин буурууллаа.

Своп хэлцлийн үлдэгдлийг бууруулснаар эдийн засагт эерэг нөлөө үзүүлээ. Дотоодын зах зээлээс худалдаж авсан алтыг цэвэршүүлж, мөнгөжүүлсэн орлогоос юанийн своп хэлцлийн ашиглалтаас хааж эхэлсэн нь төв банкны хүүний зардал болон алдагдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж, ОУВС болон бусад олон улсын санхүүгийн байгууллагын зөвлөмжийг хангахад чухал үйл явдал боллоо.

8. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЛЭЭ

Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжлийн ирэх үеийн чиг хандлагыг тодорхойлох эрх зүйн орчны цогц шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүллээ. Монголбанк банкны салбарын реформыг эхлүүлэн, санхүүгийн зуучлалын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх, финтек экосистемийн хөгжлийг дэмжих бодлогын шинэчлэлийг амжилттай өрнүүлж, салбарын тогтвортой байдлыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлсэн стратегийн алхам болов. Энэ реформын хүрээнд банкны өмчлөлд төвлөрлийг бууруулах, засаглал, хяналтын тогтолцоог сайжруулах, олон улсын стандартад нийцсэн зохицуулалт, хяналтыг хэрэгжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зэрэг зорилтуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, харилцагчид хүртээмжтэй, ил тод, дижиталчлагдсан банкны системийг бий болгоход чиглэсэн томоохон шинэчлэлүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Энэхүү өөрчлөлт хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, системийн эрсдэлтэй банкуудын нөлөөллийг сааруулах, санхүүгийн дунд хугацааны тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн дөрвөн үндсэн зарчмыг баримтлан банкуудыг илүү нээлттэй, хариуцлагатай болгох, хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, татан буугдсан тохиолдолд төлбөр барагдуулах дарааллыг тодорхой болгох, системийн нөлөө бүхий банкны тодорхойлолтыг шинэчлэх зэрэг чухал арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн банкны салбарын ил тод байдал, олон нийтийн хяналт, зохистой засаглалын түвшнийг сайжруулж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүллээ. Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран хэрэгжүүлж буй Сэндбоксын хүрээнд шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн турших боломжийг нээснээр цахим мөнгөний хэрэглээ төлбөрийн хэрэгслээс өргөжиж, үнэт цаасны захиалга, төлбөр тооцоо, бүртгэл хөтлөх зэрэг олон талын үйлчилгээнд ашиглагдах боломж бүрдлээ. Финтек байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд цахим мөнгө гаргах, төлбөрийн карт гаргах, хүлээн авах болон картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлүүдийг олгов.


Санхүүгийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн шинэчлэв. Хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг зохицуулах хуулийн шинэчилсэн найруулгаар санхүүгийн үйлчилгээний нэр томьёо, зохицуулалтын зарчмыг орчин үеийн жишигт нийцүүлж, төлбөрийн дансны ойлголт, цахим үйлчилгээ үзүүлэх боломж, хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалах зохицуулалт илүү тодорхой болж хэрэглэгч төвтэй үйлчилгээний орчныг төлөвшүүлэхэд онцгой хувь нэмэр орууллаа.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль батлагдав. Тусгай зориулалтын банк нь үнэт цаасны арилжаанд суурилсан санхүүжилтийг өргөжүүлэх, урт хугацаатай, хямд өртгийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бизнесүүдийн хөрөнгө татах боломжийг өргөтгөхөд чухал ач холбогдолтой. Ингэснээр банк төвтэй санхүүжилтийн бүтцээс хамаарал буурч, санхүүгийн зах зээлийн төрөлжилт, өрсөлдөөн нэмэгдэх суурь нөхцөл бүрдэж байна. Монголбанкны хэрэгжүүлсэн эдгээр цогц шинэчлэл нь санхүүгийн салбарын зохицуулалтын орчныг орчин үеийн олон улсын стандарттай нийцүүлэн шинэчилж, салбарын тогтвортой байдал, ил тод байдал болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд чухал үр нөлөө үзүүллээ.

9. АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭВ

Банкны салбарт активын чанарын үнэлгээг гүйцэтгэв. Монголбанкнаас банкны салбарын тогтвортой, ил тод байдал, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, олон улсын стандарттай нийцүүлэх зорилгоор активын чанарын хөндлөнгийн хараат бус үнэлгээг тогтмолжуулан хэрэгжүүлж байна. Монгол Улсад анх банкуудын активын чанарын үнэлгээг 2017 онд Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Монголбанкны санаачилгаар банкны салбарын реформын хүрээнд системийн нөлөө бүхий банкуудыг 2022 онд олон улсад нэр хүнд бүхий PwC аудитын компаниар дахин үнэлүүллээ. Энэхүү үнэлгээг Европын Төв банкны өндөр стандарттай аргачлалаар хийлгэсэн бөгөөд банкууд олон нийтэд хувьцаагаа гаргахаас өмнө актив хөрөнгийн чанар, эрсдэлийн сан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтоох, гадаад, дотоодын оролцогч талуудыг бодит мэдээллээр хангах зорилготой байв. Банкны салбар нь санхүүгийн системийн 90 хувийг дангаар бүрдүүлдэг бөгөөд системийн нөлөө бүхий 5 банк нь салбарын нийт активын 85 хувийг бүрдүүлдэг. Иймд энэхүү активын чанарын үнэлгээ нь банк, санхүүгийн салбарт нөхцөл байдлын оношилгоо хийсэн чухал үйл явдал байв.

Системийн нөлөө бүхий банкуудад хийсэн активын чанарын үнэлгээний үр дүн




Эх сурвалж: Монголбанк

Үнэлгээнд нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн багцын 70 орчим хувийг хамруулав. Активын чанарын үнэлгээнд банкны системийн нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн багцын 70 орчим хувийг хамруулж, түүнд хамаарах 300 гаруй барьцаа хөрөнгийн үнэлгээнд баталгаажуулалт хийсэн. Үнэлгээний үр дүнг банкуудын тайланд тусгуулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих болон банкны тухай хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Чанаргүй зээлийн хувь түүхэн доод түвшиндээ хүрэв. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2021 онд 11.7%-д хүрээд байсан чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2025 онд түүхэн доод хэмжээнд 4.9%-д хүрч буурлаа. Активын чанарын үнэлгээг амжилттай хэрэгжүүлснээр банкуудын хувьцааны үнэ цэнд олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлж, улмаар IPO амжилттай явагдахад чухал нөлөө үзүүллээ.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк

10. БАНКУУД НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОО

Хууль эрх зүйн шинэчлэлийг хийв. Монголбанкнаас банкны тухай хуульд “Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат хэлбэртэй байна гэж” нэмэлт өөрчлөлт оруулж, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд нийцүүлэн өөрчлөх зохицуулалтыг хийсэн. Түүнчлэн, банкуудад “Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах төлөвлөгөө”-г гарган хэрэгжүүлэхийг үүрэг болгож, биелэлтэд тогтмол үнэлэлт өгч ажиллав.

Системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа нээлттэй арилжив. 2022 оноос Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк нь компанийн хэлбэрээ нээлттэй хувьцаат компани болгон өөрчилж, нийтэд анх удаа хувьцаагаа санал болгон худалдаж, анхдагч зах зээлийн арилжаагаар 473 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Мөн Богд банк мөн нээлттэй хувьцаат компани болж, системийн нөлөө бүхий банкуудаас бусад банкууд ч хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн нь банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн томоохон алхам боллоо.


Банкуудын арилжсан хувьцааны дүн

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ₮473 ТЭРБУМ					
₮183.3 тэрбум	₮118.8 тэрбум	₮83.5 тэрбум	₮35.7 тэрбум	₮25.4 тэрбум	₮31.8 тэрбум
 ХААН БАНК	 ГОЛОМТ БАНК Сайн сайхныг саймруулна	 ТДВ ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	 ХАСBANK	 ТӨРИЙН БАНК МОНГОЛЫН АРЛЫН ХӨРӨНГӨ	 БОГД БАНК 4739 12345

Эх сурвалж: Арилжааны банкууд


Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 10 их наяд төгрөгийг давав. Монголын системийн нөлөө бүхий арилжааны банкууд олон нийтэд хувьцаагаа санал болгон худалдсанаар Монголын хөрөнгийн зах зээлд чухал хөгжилд чухал үйл явдал болов. Тодруулбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны 4 дүгээр сар ойролцоогоор 6.6 их наяд төгрөг байсан бол 5 дугаар сард 10.2 их наяд төгрөгт хүрэв. Улмаар энэ өсөлт үргэлжилсээр 2023 оны эцэст 11.6 их наяд, 2025 оны 3 дугаар улиралд 13.1 их наяд төгрөгт хүрээд байна. Ernest & Young-ийн тайланд дурдсанаар Р/В харьцаа Хас банкныг эс тооцвол бүгд 1-ээс доогуур үзүүлэлттэй байна. Энэ нь ижил түвшний орнуудтай харьцуулахад харьцангуй бага байгаа юм.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, их наяд төгрөг



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Price/ Book Value харьцаа



Эх сурвалж: Ernest & Young "Assessment of the Banking law

Олон улсын жишигт нийцсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд чухал алхам болов.

Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг Базелийн стандартад нийцүүлж, тэдэнд тавих хяналт, шаардлагыг олон улсын жишигт нийцүүлсэн нь томоохон ахиц дэвшил боллоо. Мөн системийн нөлөө бүхий банкуудад олон улсад нэр хүндтэй хөндлөнгийн аудитын компаниудаар активын чанарын үнэлгээ хийлгэж, олон нийт, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлсэн нь IPO амжилттай явагдахад чухал нөлөө үзүүллээ.

11. УУР АМЬСГАЛЫН БОДЛОГО, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ УЯЛДУУЛАХ ЧИГЛЭЛД МАНЛАЙЛЖ АЖИЛЛАВ

Монголбанк ногоон, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд манлайлан ажиллаж байна. Дэлхий нийт уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудалд идэвхтэй анхаарч, Парисын хэлэлцээр, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг 2015 онд баталсан. Монголбанк уг аянд нэгдэж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг судлах, ногоон, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд олон улсын байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж, мөнгөний бодлого, зохицуулалтын арга хэрэгслээр дэмжиж байна.

Тогтвортой санхүүжилтийн үндсэн баримт бичгүүдийг үе шаттай баталснаар салбарын эрх зүйн болон институтийн суурь бүрдэв. 2019 онд баталсан “Ногоон таксономи” нь банкны салбарыг ногоон зээлийн ангилал, тайлагналын нэгдсэн стандартад шилжүүлж, ногоон санхүүжилтийн хэмжээ, чиглэлийг ил тод, харьцуулалттай хэмжих нөхцөлийг бүрдүүлсэн бол 2022 онд батлагдсан “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг” нь 2030 он хүртэл ногоон санхүүжилтийн бодлогын зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, банкны салбарын ногоон зээлийн эзлэх хувийг 10 хувь, банк бус санхүүгийн байгууллагынхыг 5 хувьд хүргэх стратегийн зураглалыг тогтоов. Цаашлаад 2023 онд Тогтвортой хөгжлийн 17 зорилт, 142 индикатор үзүүлэлтэд нийцсэн эдийн засгийн үйл ажиллагааг 12 үндсэн салбарт ангилан тодорхойлсон “Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-уудын Санхүүжилтийн Таксономи”-ийг батлав.

Монгол Улсын Ногоон Таксономи



Монгол Улсын ТХЗ-уудын санхүүжилтийн таксономи



Эх сурвалж: Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбоо

Ногоон зээлийн бодлогын дэмжлэгийг сайжруулж, зээл олголтын өртгийг бууруулав. Монголбанкны 2021 онд баталсан Урт хугацаат своп хэлцлийн журамд “Ногоон таксономийн ангилалд багтсан зээлийн эх үүсвэрт ам.долларын хүүд 0.5%-г

нэмж тооцож болно” гэж зааснаар банкуудад валютын эрсдэлийг бууруулах замаар ногоон зээлийг тогтвортой эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлэв. Түүнчлэн, ногоон барилгын зээлийн эрсдэлийн жинг 100 хувиас 75 хувь болгон бууруулсан нь банкуудын эх үүсвэрийн өртөг болон ханшийн савлагааны эрсдэлийг мэдэгдэхүйц багасгаж, ногоон санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх үр нөлөөтэй байв.

Банкны салбарын ногоон зээлийн хэмжээ тогтмол өсөж, тогтолцооны шинэчлэл бодит үр дүнгээ өгч эхэллээ. Банкууд ногоон зээлийн тайланг Монголбанканд улирал бүр тайлагнадаг бөгөөд 2025 оны гуравдугаар улирлын байдлаар банкуудаас олгосон ногоон зээлийн үлдэгдэл 2,017.3 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн үлдэгдлийн 4.7 хувийг бүрдүүлсэн нь санхүүгийн салбар ногоон шилжилтийн санхүүжилтэд оролцох боломж бодитоор өргөжиж буйг харууллаа.

Банкуудын ногоон зээл, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын байгаль орчин нийгэм засаглал (БОНЗ)-ын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын аргачлал батлав. Банкуудын үйл ажиллагаанд БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ, удирдлагын аргачлалыг нэвтрүүлснээр тогтвортой санхүүжилтийн зарчмыг эрсдэлийн удирдлагын тогтолцоонд бүрэн шингээх суурь нөхцөлийг бүрдүүлэв. Энэ нь дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой алхам боллоо.

Алтны олборлолт, нийлүүлэлтийн үйл ажиллагааг БОНЗ-ын зарчимд нийцүүлж “Лондонгийн зарчмууд”-д нэгдлээ. Монголбанк 2024 онд Дэлхийн алтны зөвлөлөөс санаачилсан “Лондонгийн зарчмууд” багц зарчимд Колумб, Эквадор, Филиппин зэрэг улсын Төв банкуудтай хамт нэгдэв. Энэхүү зарчмууд нь төв банкуудын бичил уурхайчдаас алт худалдан авах үйл ажиллагааг албан ёсны болгож, хариуцлагатай бичил уурхайг дэмжих, албан ёсны нийлүүлэлтийн сүлжээнд оруулах зорилготой юм. Энэ нь алт олборлолт, нийлүүлэлтийг БОНЗ-ын зарчимд нийцүүлж, салбарын хариуцлагыг дээшлүүлэх чухал алхам болж байна.

Монголбанк уур амьсгалын тайлагнал, стресс тестийн стандартыг боловсруулав. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн түншлэл (NDC Partnership) болон НҮБ-ын Ази Номхон Далайн Эдийн засаг нийгмийн хороо (UNESCAP)-тай хамтран хэрэгжүүлж буй

“Төв банкийг ногоон болгох бэлэн байдлыг нэмэгдүүлэх” төсөл нь банкны салбарын уур амьсгалын стресс тестийн аргачлал, тайлагналын удирдамж, БОНЗ-ын аргачлалын үнэлгээг боловсруулж 2025 оны 5 дугаар сард “Уур амьсгалын нөлөөллийн тайлагналын удирдамж”-ийг олон нийтэд танилцуулсан нь санхүүгийн салбарын нэгдсэн стандарт, арга зүйг бий болгосон дэвшил боллоо.

Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээний тогтолцоо салбарын түвшинд бүрдэж, Монголбанк олон улсын түвшинд туршлагаа хуваалцлаа. Системийн ач холбогдол бүхий банкуудыг хамруулан зохион байгуулсан уур амьсгалын сценарийн шинжилгээ нь физик болон шилжилтийн эрсдэлийн нөлөөллийг тооцох арга зүйг бий болгож, санхүүгийн системийн уур амьсгалын эрсдэлийн мэдрэмжийг илүү нарийвчлалтай үнэлэх боломж бүрдүүлэв. Энэхүү аргачлал нь олон улсын байгууллагын анхаарлыг татаж, Монголбанк 2025 онд Бангкок хотод болсон NDC Clinic арга хэмжээнд туршлагаа амжилттай танилцуулсан нь стратегийн чадамжийн хувьд томоохон ахиц болов.

12. УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАЛАА

Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжив. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 онд жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжихэд зориулан Төв банкны репо арилжааны нөхцөлд өөрчлөлт оруулж, төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалан 2 хүртэл жилийн хугацаатай санхүүжилт олгох боломжийг бүрдүүлж байв. Улмаар 2020 оны 4 дүгээр улиралд тус арга хэмжээний хүрээнд 230 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон юм. Цаашлаад жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн эх үүсвэрийн зардлыг 10.5 хувь болгон, зах зээлийн хүүнээс 6-7 нэгж хувиар бууруулж, хугацааг уртасгах, зээлдэгчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс эхний 6 сард чөлөөлөгдөх нөхцөлийг бүрдүүлсэн нь цар тахлын үед банкуудын зээл олголт доголдсон үед зээлийн нийлүүлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах, цаашид эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдолтой байв.

“Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, экспортын орлогыг өсгөх, салбарын нэгдсэн стандарт, хууль эрх зүйн орчныг таатай болгох, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" тогтоолыг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр баталж, энэхүү тогтоолын хүрээнд малын гаралтай түүхий эд болох ноос, ноолуур, арьс ширний салбарын үйлдвэрлэлийг цогц байдлаар дэмжих “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийг 2024-2028 оны хооронд хэрэгжүүлэхээр болсон. “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн нийт төсөв 2.19 их наяд төгрөг бөгөөд үүнээс 682.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Улсын төсвийн санхүүжилт нь зээлийн хүүний дэмжлэг, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, салбарын стандарт, хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлийн ажлуудад түлхүү зарцуулагдана. Харин аж ахуйн нэгжүүдэд олгох 1.51 их наяд төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд Засгийн газрын зүгээс хүүний дэмжлэг үзүүлэх байдлаар хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохоор шийдсэн. Монголбанкнаас энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын ноос, ноолуур, арьс ширний салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаарх салбаруудын танилцуулга, ХХААХҮЯ, Монголын Арьс Ширний Холбоо, Монголын Ноос, Ноолуурын холбоодын санал, зөвлөмж, Монголбанкнаас боловсруулсан салбарын судалгаа, мэргэжилтнүүдийн санал зөвлөмж, олон улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн туршлага зэрэгт үндэслэн “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилт, үйл ажиллагааны ерөнхий зөвлөмж”-ийг боловсрууллаа.

Ноолуурын экспорт, тонн, сая.ам.доллар

Барааны нэр	2021		2022		2023		2024		2025.10	
	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн
Угаасан ноолуур	6,026.9	253.6	6,426.7	308.4	5,449.1	264.0	4,775.8	256.7	0.0	0.0
Самнасан ноолуур	424.0	16.9	857.0	93.1	1001.1	95.9	707.3	69.8	4,775.8	244.1
Нийт	6,450.8	270.5	7,283.7	401.5	6,450.2	359.8	5,483.1	326.5	4,775.8	244.1

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Ноолуурын экспортыг нэмэгдүүлэх санхүүжилтийн схемийг гарган ажиллалаа. Улсын Их Хурлаас эдийн засгийн нөхцөл байдал, зах зээл дэх ноолуурын үнийн байдлыг харгалзан ноолуурын борлуулалтыг дэмжих зорилгоор салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг судлан шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах чиглэл Монголбанканд өгсний хүрээнд Монголбанкнаас Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог олон улсын сайн жишигт нийцүүлэх ажлыг хэрэгжүүлж, ноолуурын үйлдвэрүүд түүхий ноолуур худалдан авахад зориулан вексель гаргах санхүүжилтийн схемийг гарган ажиллалаа. ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйн биржийн дэмжлэгтэйгээр ноолуур бэлтгэл, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх зориулалтаар компанийн жилийн 12 хувийн хүүтэй, энгийн вексель гаргах ажлыг 2025 онд хэрэгжүүлж эхэллээ. Мөн энэ ажлын хүрээнд Монголбанкнаас “Уул уурхайн бус экспорт ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт” сэдэвт хурал зохион байгууллаа. Тус хурлаар Монголын банкны холбоо, Ноос, ноолуурын холбоо, үйлдвэрлэгчдийн төлөөлөл, арилжааны банкууд, олон улсын санхүүгийн байгууллагууд оролцож, нөхцөл байдал болон цаашдын чиг хандлагын талаар хэлэлцлээ.

13. ИПОТЕК ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ

Ковид-19 цар тахлын үед ипотекийн зээлдэгчдэд дэмжлэг үзүүлэв. Цар тахлын улмаас иргэдийн санхүүгийн дарамтыг бууруулахын тулд ипотекийн зээлдэгчдэд өрийн дарамтыг зөөллөх шийдвэрүүдийг 2020–2021 онд гурван удаа авч хэрэгжүүлэв. Ингэснээр нийт 152 мянга гаруй зээлдэгчийн 3.1 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулахгүй нөхцөлөөр хойшлуулснаар өрхийн амьжиргаанд үзүүлэх дарамтыг богино хугацаанд бууруулахад томоохон дэмжлэг боллоо.

Ипотекийн зээлийн хүүг 6% болгон бууруулав. Хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 10 дугаар сарын 1-нээс ипотекийн зээлийн хүүг жилийн 8%-аас 6%-д шилжүүлснээр илүү олон өрх хөтөлбөрт хамрагдах боломж нээгдэж, сүүлийн зургаан жилийн хугацаанд нийт 5.6 их наяд төгрөгийн санхүүжилтээр 56 мянга орчим өрхийн орон сууцны хэрэгцээг шийдвэрлэсэн байна. Ийнхүү ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 2019 оноос хойш 101%-иар өсөж, 2025 оны 10 дугаар сарын байдлаар 6.6 их наяд төгрөгт хүрсэн байна.


Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн хөтөлбөрийг орон нутаг руу чиглүүлэн ажиллав. Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, орон нутаг дахь орон сууцжилтыг дэмжих бодлогын хүрээнд Монголбанк “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-нд хөтөлбөрийн эх үүсвэрийн 25-аас доошгүй хувийг орон нутагт хуваарилан олгохоор шийдвэрлэв. Зээлийн батлан даалтын сангаас 2022 оноос орон нутагт ипотекийн урьдчилгаа төлбөрийг 18 хувиас 12 хувь болгон бууруулсан болон 2023 оноос эхлэн Засгийн газартай хамтран орон нутагт орон сууц худалдан авч буй өрхөд эхний гурван жилд 3 хувийн хүүгийн татаастай зээл олгож эхэлсэн нь хөдөө орон нутгийн иргэдийн орон сууцны хүртээмжийг бодитоор нэмэгдүүлсэн чухал алхам боллоо.

Хөтөлбөрийн хүрээнд олгосон ипотекийн зээл, тэрбум төгрөг



Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчин бүрдсэнээр ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдлээ. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 онд батлагдсанаар Хуримтлалын сан болон Ирээдүйн өв сангийн дансуудыг Монголбанкинд нээж, Монголбанк эдгээр сангийн хөрөнгийг Засгийн газраас олгосон мандатын дагуу мэргэжлийн удирдлагын хүрээнд удирдан ажиллаж байна. Энэ хүрээнд Хуримтлалын сангийн хөрөнгийг ипотекийн хөтөлбөрт ашиглах боломжийг бүрдүүлэн Монголбанк болон Засгийн газар “Хуримтлалын сангаас орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулах ерөнхий гэрээ”-г байгуулж, мөн 2025 оны 6 дугаар сард талууд “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г шинэчлэн байгуулснаар сангийн хөрөнгийн урт хугацааны удирдлагын тогтолцоо бүрэн төгөлдөржиж, тогтвортой санхүүжилтийн орчин бүрдэв. Үүний үр дүнд Хуримтлалын сангаас 718 тэрбум төгрөгийг ипотекийн хөтөлбөрт олгосноор санхүүжилтийн хэмжээ сүүлийн таван жилийн дундажтай харьцуулахад хоёр дахин өсөж, хөтөлбөрийн хүртээмж, үр нөлөө нэмэгдлээ.

14. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ШИНЭ ШАТАНД ГАРАВ



Монгол Улсын төлбөр тооцоонд “Apple Pay” болон “Google Pay” үйлчилгээг нэвтрүүлэв. Монголбанк ISO/IEC 7816-5 стандартад нийцсэн төлбөрийн аппликейшнийг өвөрмөц байдлаар таних, аюулгүй байдлыг хангах үндэсний AID (Аппликейшн Тодорхойлогч)-ийг баталснаар төгрөгийн картыг олон улсын стандартад нийцүүлж, Apple Pay үйлчилгээг 2024 онд, Google Pay үйлчилгээг 2025 онд амжилттай нэвтрүүлэв. Ингэснээр картын аюулгүй байдал, хэрэглээний тав тух, олон улсын нийцтэй байдал эрс сайжирч, Монгол хэрэглэгчид төгрөгийн картаа гар утас, ухаалаг цаг зэрэг төхөөрөмжөөр манай улсын 150 мянга гаруй ПОС төхөөрөмж дээр ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой болж, цахим төлбөрийн экосистем өргөжлөө.

Олон улсын стандартад нийцсэн IBAN дансны дугаарлалт руу шилжив. Монголбанк төлбөр тооцооны дэд бүтцийг шинэ түвшинд гаргах зорилгоор дансны дугаарлалтын олон улсын IBAN стандартыг нэвтрүүлж, банк хоорондын гүйлгээний алдаа, буцаалтын эрсдэлийг бууруулах шинэчлэл хийлээ. Мөн олон улсын гүйлгээний мэдээллийн ISO20022 стандартад үе шаттайгаар шилжих ажлыг эхлүүлж, банк санхүүгийн байгууллагуудад шаардлагатай сургалт, бэлтгэл хангалтыг зохион байгуулсан нь Монгол Улсын төлбөрийн системийг дэлхийн түвшинд нийцүүлэх суурь өөрчлөлт боллоо. IBAN дансны дугаарлалттай болсноор олон улсын гүйлгээ илүү хурдан, найдвартай, эрсдэлгүй болж, алдаатай гүйлгээ буцаагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ дансны дугаараар банкиг ялгах боломжтой зэрэг давуу талтай юм.

Төгрөгийн картыг EMV чип технологид шилжүүлэв. Төлбөрийн картын системийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр бүрэн шинэчилж, Англи улсын "TranzWare" системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр банк хоорондын төлбөрийн картын системээр шинэ төрлийн гүйлгээнүүд дамжуулах, төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлэх зорилгоор хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх боломжтой болов. Мөн уг шинэчлэлийн хүрээнд үндэсний брэнд төгрөгийн картыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн EMV чипт суурилсан технологид шилжсэн нь картын өгөгдөл хамгаалалтыг сайжруулж, монгол хэрэглэгчдэд дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээг нэвтрүүлэв.

Үндэсний төгрөгийн картыг олон улсын сүлжээнд холбогдох чухал алхмыг хийж, гадаадад төлбөр хийх боломж нээгдэв. Монголбанк 2022 онд БНСУ-ын КТ Группийн охин компани болох “BC Card (БиСи карт)” компанитай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд “Хамтран ажиллах гэрээ”-д 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, баталгаажууллаа. Тус гэрээг байгуулснаар Үндэсний брэнд төгрөгийн картыг Солонгос Улсад, БиСи картыг Монгол Улсад харилцан төлбөрт хүлээн авах боломж бий болоход нэг алхам ойртлоо. Нэг талаас хоёр орны хамтын ажиллагааг сайжруулахын зэрэгцээ бизнес, хөдөлмөр эрхлэгч, аялал зуучлалаар хоёр улсад зорчих иргэд дотооддоо ашигладаг картаараа төлбөр тооцоогоо түргэн, шуурхай, найдвартай гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ. Нөгөө талаас ямар нэгэн хууль, эрх зүйн орчны хязгаарлалтгүйгээр санхүүгийн үйлчилгээ авах ач холбогдолтой юм.


Үндэсний цахим гүйлгээний төвийг шинэчлэв. Uptime Institute-ийн TIER II стандартаар шинэчлэгдсэн шинэ дата төв нь давхарласан цахилгаан хангамж, хөргөлт, галын хамгаалалттай, 36 серверийн хүчин чадал бүхий орчин үеийн процессингийн орчныг бий болгосноор банк хоорондын гүйлгээ, АСН+ (Автомат клиринг хаус), картын сүлжээ зэрэг үндэсний хэмжээний ажиллагааг тасалдах эрсдэлгүй болгов. Цар тахлын үед илэрсэн тасралтгүй ажиллагааны шаардлагуудыг хангаж, гадаад гүйлгээний найдвартай байдал болон кибер аюулгүй байдлын хяналт эрс сайжирсан нь энэ шинэчлэлийн гол үр дүн байв.

Бага дүнтэй гүйлгээний АСН+ системийг нэвтрүүлэв. АСН+ нь 5 сая төгрөгөөс доош дүнтэй гүйлгээг бодит цагийн горимд 24/7 тасралтгүй, эсхүл багцлан дамжуулах боломжтой болгосноор хэрэглэгчид төлбөрийн үйлчилгээг хурдан, хэмнэлттэй авах нөхцөл бүрдсэн. Мөн оролцогч байгууллагуудын өдөрт хийсэн өглөг, авлагыг харилцан суутган клиринг хийж, үр дүнг “Банксүлжээ” системээр дамжуулан дансанд тусгадаг онцлогтой тул санхүүгийн үйлчилгээнд зарцуулах хугацаа буурч, дижитал хэрэглээ өсөж, төлбөрийн системийн үр ашиг бодитоор дээшилсэн юм.

15. ЗЭЭЛЖИХ ЧАДВАРЫГ ОНООГООР ҮНЭЛДЭГ ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ

Зээлийн мэдээллийн үйлчилгээг шинэ шатанд гаргах суурь нөхцөлийг бүрдүүлэв. Зээлийн мэдээллийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн тушаалаар “Бүрэн Скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан” ХХК-д олгосон юм. Улмаар 2022 онд тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, зээлийн мэдээллийн үйл ажиллагааны талаарх бодлого, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эхлүүлсэн. Ингэснээр Монголбанкны зээлийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг бий болгох, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран ХУР мэдээлэл солилцооны системээр дамжуулан зээлдэгч өөрийн зээлийн мэдээллийг e-mongolia цахим порталаар авч зээл, төлбөрийн байдлаа хянах, санхүүгээ удирдан зохицуулах, хүндрэл чирэгдэлгүй төрийн үйлчилгээг авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн юм.

Файко зээлийн онооны системд албан ёсоор шилжлээ.



Эх сурвалж: Сайнскор

Зээлжих зэрэглэл тогтоох онооны системд шилжив. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар “Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг баталснаар зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох эрх зүйн орчин бүрдэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн түгээмэл ашигладаг зээлийн онооны загвараар зээлдэгчийн эрсдэлийг Файко оноогоор илэрхийлж, зээл болон төлбөрөө төлөх магадлалыг үнэлдэг аргачлалыг нэвтрүүллээ. Үүний үр дүнд зээлийн эрсдэлээс хамаарч зээлийн хүү ялгаатай тогтох тогтолцооны суурь бүрдэж байна. Мөн Монголбанкнаас тус хуулийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн зээл авах боломжийг хязгаарлаж буй зээлийн ангиллын мэдээллийг зээлийн мэдээллийн лавлагаанд тусгахгүй байх (зээлийн мэдээллийн лавлагааны “ангилал” баганыг хасах) арга хэмжээг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хэрэгжүүллээ.

16. БАНКНЫ САЛБАРТ ИХ ӨГӨГДЛИЙН СИСТЕМ НЭВТЭРЧ, СТАТИСТИКИЙН ЦАР ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭВ

Их өгөгдлийн системийг нэвтрүүлээ. Тоо мэдээллийн эрэлт хэрэгцээ, хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа дэлхийн чиг хандлагатай уялдуулан Монголбанк “Их өгөгдлийн систем”-ийн төслийг банкуудтай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү систем нь банкны салбарыг нийтэд нь хамарсан цогц системийн шийдэл бөгөөд банкны салбарын 250 гаруй ажилтны ачаалал буурч, мэдээллээр түргэн шуурхай хангагдаж, шийдвэрийг оновчтой, түргэн хугацаанд гаргах, бодлого боловсруулалтад машин сургалт, хиймэл оюун ухаан зэрэг дүн шинжилгээний орчин үеийн шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэх боломжуудыг бий болгох юм. Түүнчлэн, Монголбанк их өгөгдлийн системтэй зэрэгцээд өгөгдлийн удирдлагын цоо шинэ тогтолцоонд шилжиж байна.

Их өгөгдлийн системийг амжилттай суурилуулснаар олон улсын “Central Banking” институтээс шагнал хүртэв. Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд банкны салбарын статистик мэдээллийг нэг шугам, нэг загвараар хүлээн авах их өгөгдлийн системийг Монголбанк амжилттай нэвтрүүлж банкнуудаас хүлээн авдаг 70 гаруй тайлангийн нэгдсэн өгөгдлийг DAM (Data Acquisition Model)-загвараар хүлээн авч эхлээд байна. Тус систем нь олон төрлийн их хэмжээний тоон мэдээллийг түргэн шуурхай, харилцан нийцтэй цуглуулах, дэлгэрэнгүй шинжилгээ хийх боломжтойгоор хүлээн авах, нэг агуулгатай мэдээллийг давхцуулахгүй байх, цаашид тайлангийн маягтуудад өөрчлөлт ороход 2 талд хүндрэл багатайгаар шийдвэрлэх, бодлого боловсруулалтад машин сургалт, хиймэл оюун ухаан зэрэг орчин үеийн шинжилгээний арга хэрэгслийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ. Монголбанк нь их өгөгдлийн системийг амжилттай суурилуулсан нь Олон Улсын Төв банкнуудын дунд түүчээлэгч ажил болсон тул “Central Banking” институтээс шалгаруулдаг “Fintech RegTech Global Awards”-ын “The Pioneer award” буюу “Түүчээлэгч” шагналыг 2023 оны 6 дугаар сард авлаа. Тус шагналыг Их Британийн Санхүүгийн Зохицуулах Хороо 2022 онд, Тайландын төв банк 2021 онд, Францын төв банк 2019 онд, Канадын төв банк 2018 онд авч байсан түүхтэй.


Статистик мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэв. Монголбанкны статистик тоон мэдээлэл болон тайлангийн бүтцийг шинэчилж, “stat.mongolbank.mn” цахим хуудсыг ашиглалтад оруулснаар олон нийт санхүүгийн үзүүлэлтүүдийг нэг цэгээс, илүү хурдан авах боломжтой болсон юм. Гадаад өр, төлбөрийн тэнцэл, банкны салбарын үзүүлэлт зэрэг үндэсний хэмжээний чухал макро статистикуудыг монгол болон англи хэлээр тогтмол нийтэлдэг болсон нь мэдээллийн хүртээмж, олон улсын харилцаанд чиглэсэн ил тод байдлыг нэмэгдүүлсэн чухал алхам байв.

Олон Улсын Валютын Сангийн “Мэдээлэл тархаалтын тусгай стандарт (SDDS)”-д шилжлээ. Монголбанк, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаагаар 2019 онд SDDS стандартыг нэвтрүүлж, макро эдийн засаг, төсөв, санхүү, гадаад сектор, хүн ам

зүй зэрэг 20 гаруй үндсэн үзүүлэлтийг тогтоосон давтамж, хэлбэрээр олон нийтэд тогтмол, стандартчилагдсан форматтайгаар хүргэх үүргийг хүлээсэн. Энэхүү стандартын дагуу мэдээллийг дэлгэрэнгүй тайлбар, метадата зэрэгтэйгээр ил тод болгосноор статистикийн мэдээллийн итгэлцлийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагуудын үнэлгээ, харьцуулалт болон судалгаа шинжилгээний үр ашгийг дээшлүүллээ.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүйсээр ангилан статистикийн мэдээллийн санг баяжуулав. Банкны салбарын үзүүлэлтүүдийн мэдээллийг 2019 оноос хүйсээр болон байршлаар ангилан бүртгэж эхэлсэн. Ийнхүү иргэдийн зээл, хадгаламж, харилцах, бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд олгосон зээл, ногоон зээл зэрэг үзүүлэлтүүдийг хүйсээр ялган тайлагнадаг болсон нь санхүүгийн хүртээмжийн ялгааг нарийвчлалтай тодорхойлох, зорилтот бүлэгт чиглэсэн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой.

2024 оны эцсээрх хүйсээр ангилсан мэдээлэл



Эх сурвалж: Монголбанк

Тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч ажиллав. Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих хүрээнд банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 2025 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд ногоон санхүүжилтийн мэдээлэл цуглуулах тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тусгасан нь ногоон эдийн засагт шилжих үндэсний бодлоготой уялдаж байна. Энэхүү ажлын хүрээнд банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, Хөгжлийн банкныг хамруулсан ногоон зээлийн тайланг нэгтгэн олон нийтэд танилцуулсан бөгөөд энэ нь тогтвортой санхүүжилтийн ил тод байдлыг хангах чухал алхам боллоо. Санхүүгийн салбарын ногоон зээлийн үлдэгдэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 77 хувиар өсөж, 2.1 их наяд төгрөгт хүрсэн нь тогтвортой санхүүжилтийн эрэлт, нийлүүлэлт бодитоор тэлж буйг харуулсан үр дүн болов.

Судалгаа, мэдээлэл цуглуулах дэд бүтцийг шинэчлэв. “Дуудлага удирдах, хянах цогц систем”-ийг нэвтрүүлж, “Иргэдийн инфляцын хүлээлтийн судалгаа”, “Бизнесийн төлөвийн судалгаа” зэрэг голлох судалгааг шинэ аргачлалаар хэрэгжүүлснээр мэдээлэл хурдан, хэмнэлттэй, чанарын шууд хяналттайгаар цуглуулах боломж бүрдсэн. Энэ нь судалгааны үр дүнгийн цаг хугацааны нарийвчлал, бодит байдлыг чанаржуулж, цаашдын макро эдийн засгийн шинжилгээнд ашиглах панел өгөгдлийн сан бүрдүүлэх нөхцөлийг бий болгож байгаа юм.

17. ИРГЭДЭД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭВ

Иргэдэд санхүүгийн боловсрол олгох, санхүүгийн луйвартай тэмцэх цуврал аянуудыг зохион байгуулав. Сүүлийн жилүүдэд Монголбанкнаас олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих бодлогын хүрээнд санхүүгийн залилан луйвраас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх мэдлэг, мэдээллийг олгох зорилгоор “Ятгах тусам нягтал”, “Нягтлах тусам аюулгүй” цуврал аяныг Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо болон арилжааны банкуудтай хамтран улсын хэмжээнд зохион байгууллаа. Аяны үр дүнд гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад учирсан хохирлын хэмжээ буурч, хэрэг бүртгэл буурч, хэрэг шийдвэрлэлт өссөн дүнтэй байв.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлж, санхүүгийн боловсрол олгох арга хэлбэрийг өргөтгөв. “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран, Европын холбооны дэмжлэгтэйгээр “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсруулав. Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүү, эдийн засгийн мэдлэгийг дэмжих зорилгоор “Дэлхийн мөнгөний долоо хоног-2021”, “Дэлхийн хуримтлалын өдөр-2021”, “Ятгах тусам нягтал-2021” аянуудыг тус тус зохион байгуулж, цахим орчинд 2.6 сая иргэнд хүргэж, хамтрагч байгууллагуудын оролцоотойгоор 360 орчим мянган хүнд санхүүгийн боловсрол олгох сургалтыг хийв. Мөн Монгол Улсын банкны салбарын ажилтанд тавигдах нэгдсэн шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэхээр Монголбанк, Монголын банкны холбоо, Монголын банк санхүүгийн академи, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан хамтран “Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”-ийг дагалдах журам болон сургалтын хөтөлбөрийн хамт хэрэгжүүлж эхлэв.



Иргэдэд санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох аянууд

Иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг хэрэгжүүлж, Level-UP хөтөлбөрийг эхлүүллээ. Иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Монголбанк холбогдох байгууллагууд хамтран 2025 онд “Дэлхийн мөнгөний долоо хоног”, “Дэлхийн хуримтлалын өдөр”, “Дансаа бүү ашиглуул” зэрэг аянуудыг амжилттай зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 3.7 сая орчим хүнд шууд болон шууд бусаар хүрч ажиллав. Ахлах ангийн сурагчдад

санхүүгийн боловсрол олгох “Level-UP” хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурлын даргын санаачилгаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Боловсролын Ерөнхий газар, Хадгаламжийн даатгалын корпорац хамтран Говь-Алтай, Ховд, Увс, Завхан, Орхон, Булган аймгууд болон нийслэлийн 6 дүүрэгт амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөр нь сурагчдад мөнгийг оновчтой удирдан санхүүгийн зөв шийдвэр гаргаж сурах, зүй зохистой хэрэглээнд дадах, эрсдэлийг үнэлэх чадвартай, хуримтлалтай иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор хэрэгжиж, нийт 5033 сурагч, 149 багш хамрагдлаа. Түүнчлэн, Өмнөговь аймгийн Даланзадгад суманд “Санхүүгийн боловсролын төв”-ийг нээж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Aflatoun International байгууллагын Азийн бүсийн зохицуулагчийг Монгол Улсад урьж, сургалт, уулзалтууд зохион байгуулж, туршлага солилцлоо.

Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь шинэчлэгдэн хэвлэгдлээ. Монголбанк, Санхүү эдийн засгийн их сургууль, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь”-ийг шинэчлэх ажлыг гүйцэтгэж, хэвлэмэл бүтээлийг олны хүртэл болголоо. Тайлбар толийг олон нийтийн хүртээл болгосноос гадна шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлж, илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгохын тулд салбарын мэргэжилтнүүд, судлаачид, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг хамруулан хэлэлцүүлэг зохион байгууллаа. Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толийг мөн etoli.mn хаягаас цахим хэлбэрээр ашиглах боломжтой боллоо.

18. ИХ ХААНЫ ХӨШӨӨГ ҮНДЭСНИЙ МУЗЕЙД ЗАЛАВ

Их хааны алтан хөшөөг бүтээлгэж Чингис хаан үндэсний музейд залав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны зөвлөмжийн хүрээнд бүтээсэн Чингис хааны алтадсан хүрэл баримлыг Монгол төрийн бэлгэдэл Төрийн тамганы хамт Чингис хаан музейн 9-р давхрын хүндэтгэлийн танхимд байршуулж, 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав. Тус музейд байрлаж буй "Чингис хаан" хөшөө нь Монгол улсад анх удаа 3D технологиор бүтээгдсэн бөгөөд хөшөөг Итали улсын Сэргэн мандалтын өлгий нутаг Флоренци хотод хүрлээр цутгуулж, алтадсан. Мөн "Их Монгол Улсын Тамга"-ыг алтаар цутгуулж, хөшөөний суурь нь дэлхийд алдартай каррара гантигаар урлагдсан. Хөшөөний гэрэлтүүлгийн ажлыг олон улсын музейн гэрэлтүүлгийн шаардлагыг хангасан орчин үеийн чанартай мэргэжлийн музейн гэрэлтүүлгээр хийсэн. Баримал нь 7.0 метр, 6.3 метр, 7.5 метр хэмжээтэй монументаль урлагийн бүтээл болсон. "Чингис хаан" алтадсан хүрэл баримлын нээлтэд зориулан "Чингис хаан баримал" каталогийг эмхэтгэн хэвлүүлж, олон нийтэд сурталчлан танилцуулав.

Их хааны алтан хөшөө



Imperial Visit to Mongolia алт, мөнгөн зоос



Эх сурвалж: Монголбанк

Түүх, дурсгалын сэдэвт дурсгалын зооснууд бүтээж, үндэсний соёлын өвд үнэтэй хувь нэмэр орууллаа. Монгол Улсад банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойд зориулан Монголбанк 100 жил 5 гр, 2 унц, 5 унц, Хубилай хааны зарлиг 1 унц, 5гр-ын ялтсан мөнгөн тэмдэгт, Хос мөнгөн луу 2 унцын мөнгөн зоос, Чингис хаан 1кг -ийн зоосыг үйлдвэрлүүлэн хүлээн авч олон нийтэд танилцуулаа. Мөн Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Япон улсын Мацүра хотын Такашима арлын далайн гүнээс илэрсэн Хубилай хааны Усан флотын цэргийн армийн хөлөг онгоцны дурсгал, тус түүхэн үйл явдлын 750 жилийн ойг тохиолдуулан "Хубилай хааны усан флот" дурсгалын зоосыг үйлдвэрлүүлж зоосны нээлтийн үйл ажиллагааг Япон Улсын Фукуока хотод зохион байгуулав. Дурсгалын 5000 төгрөгийн мөнгөн дэвсгэртийг

цөөн тоогоор үйлдвэрлэж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс гүйлгээнд гаргахаас гадна "Хубилай хааны зарлиг-Монгол банк 100 жил" сэдэвт торгон маркийг бүтээлгэж, нээлтийн үйл ажиллагаа 6 дугаар сарын 2-ны өдөр Монгол орон даяар нэгэн зэрэг боллоо.

Монгол-Итали дурсгалын ялтсан зоос гаргав. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Гэгээн Ширээт Улсын төрийн тэргүүн Пап Францис 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хийсэн түүхэн айлчлалын хүрээнд Монголбанк, Бүгд Найрамдах Итали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам хамтран гаргасан "Монгол-Итали" дурсгалын ялтсан зоосны нээлтийг хийлээ. Уг дурсгалын ялтсан зоосонд Ромын Пап IV Инносент энх тайвныг хүсэн Монголын их хаан Гүюгт бичсэн захидлыг дипломат элч Плано де Карпини гардуулж байгааг дүрсэлдэг. Энэхүү үйл явдал нь техник, технологийн хөгжилтэй зэрэгцэн дурсгалын зоосыг хэлбэр хийцийн хувьд олон төрлөөр үйлдвэрлэх, түүх соёлын өвийг олон нийтэд хүртээмжтэй таниулах үйл хэрэгт томоохон ахиц дэвшил боллоо.

Монгол-Итали дурсгалын ялтсан зоос



Эх сурвалж: Монголбанк

19. МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨНДРӨӨР ҮНЭЛЭВ.

Монголбанкны бодлого, үйл ажиллагааг өндрөөр үнэлэв. Өнгөрсөн жилүүдэд олон улсын байгууллагуудаас Монголбанкны бодлого, үйл ажиллагааг өндрөөр үнэлж, нэр хүндтэй шагналуудыг олголоо. Тухайлбал, 2020 онд төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлийг илүү хүртээмжтэй болгоход чиглэсэн бодлого, үйл ажиллагааг үнэлж, Forbes сэтгүүлээс зохион байгуулдаг “Forbes Mongolia Property Awards” шалгаруулалтаас “Барилгын салбарын амжилт” шагналыг хүртлээ. 2023 онд төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд банкны салбарын статистик мэдээллийг нэг шугам, нэг загвараар хүлээн авах их өгөгдлийн системийг Монголбанк амжилттай нэвтрүүлж, банкнуудаас хүлээн авдаг 70 гаруй тайлангийн нэгдсэн өгөгдлийг DAM (Data Acquisition Model)-загвараар хүлээн авч эхэлсэн нь олон улсын төв банкнуудын дунд түүчээлэгч ажил болсон тул “Central Banking” институтээс “Fintech RegTech Global Awards”-ын “The Pioneer award” буюу “Түүчээлэгч” шагналыг гардуулав. Мөн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор банкныг нээлттэй болон хаалттай хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуульд нийцүүлэн өөрчлөх ажил амжилттай хэрэгжиж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөхөд нөлөөлснөөр “Grand Bull Awards 2023” шагналыг хүртлээ.

Монголбанкны Ерөнхийлөгчийг өндрөөр үнэлэв. Мөн “Global Finance” сэтгүүлээс мөнгөний бодлогын хэрэгжилт, инфляцын тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт, валютын ханшийн тогтвортой байдал, төлбөрийн системийн шинэчлэл зэргийг харгалзан үзэж, Монголбанкны Ерөнхийлөгчид сүүлийн 2 жил дараалан “А-” үнэлгээ өглөө. Түүнчлэн, Монгол Улсын эдийн засаг, бизнесийн салбарын хөгжил, бүтээмжийг түүчээлэн манлайлсан байгууллага, хувь хүмүүсийг тодруулдаг “Bloomberg TV Mongolia Catalyst-2025” шагнал гардуулах ёслолын үеэр Монголбанкны Ерөнхийлөгч “Economic Catalyst” шагналыг гардан авлаа.

“Central Banker report Cards” тайлан - 2024

The central bankers earning an “A-” grade in 2024		
Cambodia	Chea Serey	A-
Canada	Tiff Macklem	A-
Costa Rica	Róger Madrigal López	A-
Dominican Republic	Héctor Valdez Albizu	A-
European Union	Christine Lagarde	A-
Guatemala	Alvaro Gonzalez Ricci	A-
Indonesia	Perry Warjiyo	A-
Jamaica	Richard Byles	A-
Jordan	Adel Al-Sharkas	A-
Mongolia	Byadran Lkhagvasuren	A-

“Central Banker report Cards” тайлан - 2025

The central bankers earning an “A-” grade in 2025		
Cambodia	Chea Serey	A-
Czech Republic	Aleš Michl	A-
Dominican Republic	Héctor Valdez Albizu	A-
Egypt	Hassan Abdalla	A-
Ethiopia	Mamo Mihretu	A-
European Union	Christine Lagarde	A-
Guatemala	Alvaro Gonzalez Ricci	A-
Mongolia	Byadran Lkhagvasuren	A-
Philippines	Eli Remolona	A-
Serbia	Jorgovanka Tabaković	A-
Singapore	Chia Der Jiun	A-
South Africa	Lesetja Kganyago	A-

Эх сурвалж: Global Finance: Central Banker report Cards

20. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭВ

Олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэв. Азийн хөгжлийн банкнаас эдийн засгийн сорилтын үед дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газарт 100 сая ам.долларын яаралтай тусламжийн зээлийг олгосон. Түүнчлэн, 2022 онд дотоодын банкууд олон улсын санхүүгийн байгууллагуудаас нийт 430.5 сая ам.долларын валютын эх үүсвэр татаж, Монголбанктай урт хугацаат своп хэлцэл байгуулжээ. Хөгжиж буй орнуудын хөрөнгийн орох урсгал татарч буй өнөөгийн нөхцөлд дээрх санхүүжилтүүд нь Монгол Улсын төлбөрийн тэнцлийн дарамтыг зөөлрүүлж, валютын нөөцийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлж байна. Монголбанк нь АНУ-ын Нью-Йорк хотод Монгол Улсын банкны салбарт хөрөнгө оруулалт татах хөрөнгө оруулагчдын уулзалтыг анх удаа амжилттай зохион байгууллаа. Мөн олон улсын санхүүгийн корпорац, Европын сэргээн босголт хөгжлийн банктай уул уурхайн бус экспортыг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлэх, тогтолцоог бүрдүүлэх чиглэлд хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

Олон улсын төв банкны жишигт хүрэх, дэлхий нийтээр хэрэгжүүлж буй бодлогын шинэ сорилт, түүнийг судлахад анхаарч гадаад хамтын ажиллагааныхаа цар хүрээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэв. Энэ хүрээнд Монгол-Хятадын банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааны дугуй ширээний уулзалт, “Монгол-Солонгосын хамтын ажиллагаа: Өнөө ба ирээдүй” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн, Дэлхийн банк, ОУВС-гийн жилийн хурал, Хонконгийн мөнгөний удирдах газар (НКМА) болон Олон улсын төлбөр тооцооны банкнаас (BIS) хамтран зохион байгуулсан Дээд түвшний бага хурал, Бүгд Найрамдах Армени Улсад мөнгөн тэмдэгтийн Дээд хэмжээний чуулган зэрэг хурал, уулзалтуудад панелистаар оролцож, Киргиз улсын банк хоорондын процессингийн төв, БНСУ-ын КТ группийн “БиСи Карт” зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Мөн Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба нь 2023 онд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Макаогийн Санхүүгийн мэдээллийн алба Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав. Мөн Монголбанк 2025 онд ОУВС ба Дэлхийн банкны, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны жилийн уулзалт, Британийн парламентын төлөөлөлтэй хийсэн уулзалт, Монгол-БНСУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны бага хуралд оролцож, худалдаа, хөрөнгө оруулалт, банк санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, олон улсын зах зээл дэх интеграци, хөгжлийн түншлэлийн талаар санал солилцон, харилцааг шинэ шатанд бэхжүүллээ.

Корреспондент банкны харилцааг өргөжүүлэх чиглэлээр ахиц гаргалаа. Монгол Улсын гадаад төлбөр тооцооны тасралтгүй байдлыг хангах, санхүүгийн салбарын харилцаанд дэмжлэг үзүүлэх, корреспондент харилцааг бэхжүүлэх хүрээнд Монголбанкнаас үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажиллаж байна. Энэ хүрээнд АНУ-ын талд албан захидал хүргүүлж, харилцан мэдээлэл солилцсоны үр дүнд арилжааны банкууд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж бүрдэж, АНУ-ын BNY Mellon банканд ам.долларын данс нээж эхэллээ. Түүнчлэн, арилжааны

банкуудын олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах ажлыг дэмжсэнээр ХБНГУ-ын ODDO BHF SE банканд ам.долларын ностро данс нээгдлээ. Эдгээр нь гадаад төлбөр тооцоог шуурхай хийх, шилжүүлгийн зардал буурах зэрэг үр дүнг бий болгох юм. Мөн энэ онд корреспондент банкны харилцааг улам өргөжүүлж, олон улсын нэр хүнд бүхий JPMorgan банктай ам.долларын төлбөр тооцооны чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлж, ам.долларын ностро харилцах дансыг JPMorgan New York салбар банканд нээлээ.

21. ДҮГНЭЛТ

Сорилт, шинэчлэлийн он жилүүд байв. Өнгөрсөн 6 жилийн хугацаа нь Монгол Улсын эдийн засаг, банк салбарт томоохон өөрчлөлт бий болсон сорилт, шинэчлэлийн он жилүүд байлаа. Монголбанк нь дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахал, геополитикийн эрсдэл, олон улсын худалдааны хурцадмал байдал, дотоодын эдийн засгийн хүндрэлүүдийг даван туулахын зэрэгцээ эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, банкны салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиглэлээр цогц бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүний үр дүнд нь макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч, банкны салбарын реформыг амжилттай хэрэгжүүлж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүллээ.

Цар тахлыг хямралыг амжилттай даван туулж, богино хугацаанд саарал жагсаалтаас гарав. Монголбанкнаас цар тахлын үед төв банкуудын сайн туршлагыг судалж, зээл санхүүжилтийн багц арга хэмжээг хэрэгжүүлснээр, эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг бууруулан, 176 мянга гаруй ажлын байрыг хадгалж, хэрэглээ болон үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжив. Ингэснээр богино хугацаанд эдийн засаг сэргэж, ДНБ-ий өсөлт цар тахлын өмнөх үеийн энгийн түвшинд хүрэв. Мөн Монголбанк, түүний дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба бусад холбогдох байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажилласнаар богино хугацаанд саарал жагсаалтаас гарч чадсан төдийгүй ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн Ази, Номхон далайн анхны орон, дэлхийд 5 дахь орон болов.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалав. Инфляцын түвшин нэг оронтой тоонд 26 сар дараалан хадгалагдаж, валютын ханшийн хэлбэлзэл 2010-2019 онтой харьцуулахад 1.5 дахин буурч, ГВАН нөөц 6.0 тэрбум ам.долларт болж түүхэн дээд түвшинд хүрлээ. Үүний зэрэгцээ Монгол Улсын Хөгжлийн банкны Евро бонд, Самурай бонд, Засгийн газрын Гэрэгэ бонд болон хувийн секторын бондын төлбөрүүдийг амжилттай төлж, Төв банкны үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээний хүрээнд авч ашигласан хэлцлийн дүнг 6 тэрбум юаниар бууруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл 2024, 2025 онуудад дараалан дээшилснээр “BB” төлөвт хүрч, түүхэн дээд түвшиндээ хүрлээ.

Банкны салбарын реформыг амжилттай хэрэгжүүлж байна. Банкны системийн эрсдэл даах чадварыг үргэлжлүүлэн сайжруулж, олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчныг бий болгов. Улмаар банкны салбарт активын чанарын үнэлгээг олон улсын стандартын дагуу хийж, арилжааны банкууд нээлттэй хувьцаат компани болсноор банкны салбарын ил тод байдал, эрсдэлийн удирдлагыг шинэ түвшинд гаргалаа. Үр дүнд системийн нөлөө бүхий банкууд анхдагч зах зээлийн арилжаагаар 473 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 10 их наяд төгрөгийг давж, санхүүгийн зах зээлийн экосистемийн хөгжилд түүхэн үйл явдал болов. Түүнчлэн, олон улс төлбөрийн хэрэгсэл Apple Pay, Google Pay Монгол Улсын төлбөр тооцооны системд нэвтэрч, дэлхийн төлбөрийн системийн хөгжилтэй хөл нийлүүлэн хөгжиж буйг илтгэсэн чухал алхам болов. Банкны салбарын реформын үргэлжлэл болж

Монголбанк “Их өгөгдлийн систем”-ийн төслийг банкуудтай хамтран хэрэгжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зээлдэгчийн эрсдэлийг үнэлдэг, зэрэглэл тогтоох Файко онооны системийг нэвтрүүллээ.

Уур амьсгалын эрсдэлийг бууруулж, уул уурхайн бус экспортыг дэмжив.

Монголбанк ногоон, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд манлайлан ажиллан Тогтвортой санхүүжилтийн үндсэн баримт бичгүүд болох “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”, “Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-уудын Санхүүжилтийн Таксономи”-ийг баталж, банкны салбарын ногоон зээлийн эзлэх хувийг 10 хувь, банк бус санхүүгийн байгууллагынхыг 5 хувьд хүргэх суурь нөхцөлийг бүрдүүлэв. Түүнчлэн, алтны олборлолт, нийлүүлэлтийн үйл ажиллагааг БОНЗ-ын зарчимд нийцүүлж “Лондонгийн зарчмууд”-д нэгдсэн юм. Мөн уул уурхайн бус экспортыг дэмжих, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй санхүүжилт олгон, ноолуурын экспортыг нэмэгдүүлэх санхүүжилтийн схемийг гаргаж, “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа.

Монголбанкны бодлого үйл ажиллагааг өндрөөр үнэлж, гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэв. Монголбанкны бодлого, үйл ажиллагаа олон улсын байгууллагуудаас өндрөөр үнэлж, 2020 онд “Forbes Mongolia Property Awards” шалгаруулалтаас “Барилгын салбарын амжилт”, 2023 онд их өгөгдлийг амжилттай нэвтрүүлснээр “Central Banking” институтээс “Fintech RegTech Global Awards”-ын “The Pioneer award” буюу “Түүчээлэгч”, банкууд нээлттэй компани болж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөхөд нөлөөлснөөр “Grand Bull Awards 2023” шагналыг тус тус хүртэв. Монголбанкны Ерөнхийлөгч 2024, 2025 онуудад “Global Finance” сэтгүүлд 2 жил дараалан “А-” үнэлгээ авсан төдийгүй “Bloomberg TV Mongolia Catalyst–2025”-аас “Economic Catalyst” шагнал хүртээд байна. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд идэвх чармайлт гаргасны үр дүнд корреспондент банкны харилцааг ахиулж, гадаад төлбөр тооцоог илүү үр ашигтай гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ.